

Шүүгчийн ажил үүргээ гүйцэтгэх үйл ажиллагаанд шашин шүтэх, эс шүтэх эрх бусад улс оронд лавлагаа

Шүүгчийн ажил үүргээ гүйцэтгэх үйл ажиллагаанд шашин шүтэх, эс шүтэх эрх нь нөлөөлдөг эсэх, ардчилал, хүний эрх, эрх зүйн хөгжлийн өндөр түвшинд хүрсэн улс орнуудад энэ харилцааг хэрхэн зохицуулдаг, тодорхой төрлийн кейс байвал түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаар судалгаа, мэдээлэл бэлтгэх ажлын хүрээнд ШЗССТ-ийн судлаач-багш Ч.Содхүү, сэтгэл зүйч Т.Энхгэрэл нарын бэлтгэсэн лавлагааг танилцуулж байна.

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

Америкийн нэгдсэн улсын шүүгч томилох ерөнхий схем.

1. Ерөнхийлөгч санал болгох- 2.Хууль зүйн Департамент/FBI- 3.Америкийн Барын Ассоциаци- /нэр дэвших гэж байгаа хүмүүс/ 4.Сенатын шүүх хороо- 5.Сенат

Мөн дээрээс нь бичигдээгүй хэм хэмжээнүүд байдаг бөгөөд тэдгээр хэм хэмжээгээр шүүгчид нэр дэвшигчийг ёс зүйн хувьд шалгадаг.

Шүүгчид нэр дэвшигч хэд хэдэн нэр цугларсны дараа Хууль зүйн Департамент нэр дэвшигч бүрийг шалгаруулалтад оруулдаг. Тэд нэр дэвшигчийн **зан араншин, үйл байдлын** талаар судлахыг Холбооны Мөрдөх Товчоонд /FBI/ даалгаж болно. Хууль зүйн Департаментын үүрэг нь санаачлагч гэхээсээ илүү шалгагч байдаг. Нэр дэвшигчдийг хэн тодруулснаас үл хамааран Хууль зүйн Департаментын гол үүрэг бол тухайн нэр дэвшигчийн хувийн, мэргэжлийн болон улс төрийн дүр төрхөд үнэлгээ өгөх юм. Ингэхдээ шүүн таслах ажиллагаанд нөлөөлөх хувийн байдал, шударга байдлыг харгалзан шалгадаг.

Америкийн Барын Ассоциаци

50 гаруй жилийн туршид АБА- ийн Холбооны Шүүхийн Хороо холбооны шүүхийн суудалд нэр дэвшигчдийн **мэргэжлийн ба ирээдүйн чадал чадварт** үнэлгээ өгөхөд гол үүрэг гүйцэтгэж иржээ. АНУ-ын бүх тойргийг төлөөлсөн 15 гишүүнтэй тус хороо дараах гурван гол шалгуураар нэр дэвшигчдийг үнэлдэг байна. Үүнд: шүүгчийн **зан төлөв байдал**, мэргэжлийн ур чадвар, **ёс суртахууны шударга байдал**.

Тус хороогоор үнэлүүлсэн нэр дэвшигчдийн батлагдсан нь “чадвартай” ба “өндөр чадвартай” гэдэг үнэлгээ авдаг бол батлагдаагүй нэр дэвшигчдэд “чадваргүй” гэсэн үнэлгээ өгдөг юм. Энэ мэт байдлаар олон шатны шалгуураар АНУ-д шүүгчээр томилогдог бөгөөд эдгээр шалгуурыг давснаар шүүгчийн хувьд эрх зүйн хүрээнд шударга хувийн ашиг сонирхлоос ангид шийдвэр гаргах боломжтой гэж үздэг

ХОЛБООНЫ ШҮҮГЧДЭД АВАХ САХИЛГЫН АРГА ХЭМЖЭЭ

Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн дагуу томилогдсон холбооны бүх шүүгчид “сайн сахилга бат”-ыг баримтлан ажлаа хийнэ гэдэг нь насан туршдаа буюу ажлаасаа сайн дураараа чөлөөлөгдөх хүртэл гэсэн үг байдаг. Шүүгчийн суудлаас тэднийг зайлуулах тохиолдол бол зөвхөн импичмент /Төлөөлөгчдийн танхимын ял/ болон Сенатын буруушаасан шийдвэр байдаг. Үндсэн хууль /дээд шүүхийн шүүгчдийн талаарх/ ба хууль эрх зүйн стандартуудын /давж заалдах шатны шүүх ба анхан шатны шүүхийн шүүгчдийн талаарх/ шаардлагын дагуу импичментийг “төрийн урвалт, хээл хахууль, болон бусад хүнд гэмт хэрэг, буруу үйлдэл” хийсэн тохиолдолд оногдуулдаг. Импичментэд орсон шүүгчийг Сенатын өмнө авч хэлэлцэж Сенатын гуравны хоёрын саналаар буруутай гэсэн шийдвэр гарвал ажлаас нь чөлөөлдөг.

1789 оноос хойш Төлөөлөгчдийн танхим дөнгөж 13 шүүгчийн эсрэг импичментийн ажиллагааг эхлүүлсэн бөгөөд ийнхүү импичментэд албан ёсоор арга хэмжээ авхуулахаасаа өмнө мөн адил 13 шүүгч сайн дураараа огцорсон байна. Дээрх импичментэд орсон 13 шүүгчээс 7-г нь л албан тушаалаас нь огцруулах шийдвэр гаргаж байжээ.

Сонирхлын зөрчил үүсэх нь тодорхой хэргийг шүүж байгаа нь **илэрхий**, шүүх танхимд аль нэг талыг илтэд баримталсан, хувийн ба мэргэжлийн зан чанар, үйлдэл нь шүүх ажиллагаа явуулахад нь сөргөөр нөлөөлж байгаа шүүгчийн асуудлыг түүхэн явцад бусад шүүгчдийн зүгээс зөөлөн сануулга авахаас хэтрэхгүй арга хэмжээ авч иржээ.

Доод шатны шүүхийн шүүгчдэд нөлөөлөхүй

Заримдаа дээд шатны шүүхээс тодорхой стандарт гаргаж өгөөгүй хэргийг доод шатны шүүх шийдвэрлэх ёстой болдог. Энэ тохиолдолд доод шатны шүүхийн шүүгчид тэдэнд ирсэн хэргийг шийдвэрлэхийн тулд заавар удирдамжийг хаа нэгтэйгээс хайх ёстой болно. Нэгэн **судалгаанд** дурдсанаар, ийм байдалд орсон доод шатны шүүхийн шүүгчид “өөрсдийн намын харьяалал, үзэл суртал, **эсхүл шашин шүтлэгийн хэм хэмжээ** зэрэг тун олон янзын хүчин зүйлээс тухайн хэргийг хэрхэн шийдвэрлэх санаагаа олж авч байж байжээ”.

Дээд шүүх 1937 оноос эхлэн иргэний эрх чөлөөний асуудлууд-тэр дундаа ялангуяа үг хэлэх болон **шашин шүтэх эрхийг** үндсэн хуулиар баталгаажуулахад гол анхаарлаа хандуулж байв.

АНУ-ын үндсэн хуулийн ЗУРГАДУГААР ЗҮЙЛ:

Энэхүү Үндсэн хууль, түүнчлэн Нэгдсэн Улсад түүнийг хэрэгжүүлэхээр тогтоосон хуулиуд Нэгдсэн Улсын нэрийн өмнөөс байгуулсан буюу байгуулах бүх Гэрээний нэгэн адил Улсын Дээд Хууль мөн бөгөөд тэдгээр нь тусгаар Муж улсуудын Үндсэн хууль, бусад хуультай зөрчилтэй байлаа ч Муж улс бүрийн шүүгчид гагцхүү Нэгдсэн Улсын Үндсэн хуулийг заавал дагаж мөрдөх үүрэг хүлээнэ. Дээр дурдсан Сенатын гишүүд болон Төлөөлөгчид, тусгаар Муж улсуудын хууль тогтоох хурлуудын гишүүд нэгэн адил Нэгдсэн Улс хийгээд тугаар Муж улсуудын Гүйцэтгэх болон Шүүх засаглалын бүх албан тушаалтан энэхүү Үндсэн хуулийг биелүүлэхээр ёс төртэй амлалт буюу Тангараг өргөнө.

Харин Нэгдсэн Улсын ямар нэгэн албан тушаал хаших эсхүл төрийн итгэл хүлээхэд шашин шүтлэг шалгуур нөхцөл болох ёсгүй.

Судалгаа:

2009 онд АНУ-ын Небраска муж улсын Линколны их сургуулийн судлаачид "Шүүгчийн шашин шүтлэг шийдвэр гаргалтад нөлөөлдөг үү?" сэдвийн хүрээнд судалгаа хийсэн байна. Үүнд:

Бусад Америкчуудын нэгэн адил шүүгч нь шашин шүтэх, гүн гүнзгий итгэл үнэмшилтэй байж болно. Хэдийгээр тэдний шашны итгэл үнэмшил нь ихэнхдээ ажлын гүйцэтгэлд нь саад болдоггүй ч шүүгчдийн шашин шүтлэг нь заримдаа асуудал үүсгэдэг. Жишээлбэл, Алабама мужийн Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Рой Мурын хэргийг 2003 онд 5300 фунт жинтэй “Арван зарлиг”-ийн хөшөөг мужийн шүүхийн байрны тойрогт байрлуулж, түүнийг зайлуулахаас татгалзсаны дараа огцруулсан. Тэрээр "Алабамагийн бүх иргэдэд Иудей-Христийн Бурханы бүрэн эрхт байдал, төр, сүмд итгэх итгэлээ сануулахын тулд" хөшөөг босгосон хэмээн тайлбарлаж байжээ. Шүүгчийн нэр дэвшүүлэх, баталгаажуулах үйл явцад шашин, түүний шүүгчийн хандлагатай холбоотой асуудал ч гарч ирдэг.

Судалгааны таамаглал: Шүүгчийг сонгохдоо шашныг чухалчлах уу? Тухайн шүүгчийн шашин шүтлэг болон шийдвэрийн хооронд харилцан хамаарал байдаг уу? Жишээлбэл,

еврей шүүгчид протестант шүүгчдээс илүү эрүүгийн хэргээр яллагдагчдад илүү эелдэг хандах уу? Евангелийн шүүгчид цаазаар авах ялыг дэмжих үү? Олон тооны хэргийг шийдвэрлэж буй мэргэжлийн хүмүүсийн хувьд шүүгчид өөрсдийн шашны итгэл үнэмшил зэрэг хууль бус хүчин зүйлсийг үл тоомсорлож чадна гэж найдаж болох ч шүүгчдийн шашин шүтлэг, ур чадварын хоёр тал нь ихээхэн санаа зовоосон асуудал бөгөөд наад зах нь тэдний шийдвэрт нөлөөлөх магадлалтайг харуулж байна.

<https://digitalcommons.unl.edu/ajacourtreview/300/>

Тус судалгааны дүгнэлт:

Шүүх нь ихэвчлэн баримт, хууль эрх зүйн нөхцөл дээр тулгуурласан хувийн сэтгэл хөдлөлийн оролцоогүй шийдвэр гаргадаг гэж дүрсэлдэг. Харин шүүгчдийн талаарх эмпирик судалгаанаас үзэхэд сэтгэл зүй, хандлага, суурь хүчин зүйлүүд нь шийдвэр гаргалтад чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Ерөнхийдөө шүүгчдийн шийдвэр гаргахад өөрсдийн шашин шүтлэгтэй холбоотой системчилсэн ялгаа байдаг бололтой. Еврей шүүгчид дунджаар илүү либерал байдаг нь өөрсдөө үндэстний хувьд гаднын улсуудад статусын улмаас дарагдсан, эрхээ хасуулсан зэрэг түүхтэй нь холбоотой гэж хэлж болно.

Гэсэн хэдий ч энэ төрлийн асуудалд "албан ёсны еврей байр суурь" байдаггүй бөгөөд энэ нь еврей шүүгчдийг янз бүрийн хэргүүд дээр сул дорой хүмүүсийн талд байх боломжийг үүсгэдэг. Католик шүүгчдийн либерализм нь хувь хүнээс хамаарч өөр өөр байдаг. Католик шашны шүүгчид зарим асуудалд католик биш хүмүүсээс илүү либерал, харин зарим асуудалд илүү консерватив байдаг. Энэ хэв маягийн нэг тайлбар нь Католик сүм нийгмийн бодлогын олон асуудлаар өөр өөр байр суурь баримталж ирсэн бөгөөд сүсэгтэн олон католик шашинтнууд ч үүнийг дагаад баримтлах байх суурь нь өөрчлөгдөж ирсэн. Евангелийн шүүгчид харьцангуй консерватив байдаг.

Судалгааны арга зүй нь шашин шүтэх эрх чөлөөний нэгэн адил шашин шүтлэгтэй болон шашин огт шүтдэггүй шүүгчдийг хоёуланг нь судалсан. Үүний үндсэн дээр шүүгчдийн асуудлыг ойлгох, шийдвэрийг урьдчилан таамаглахад, тогтооход шашин шүтлэг нь бас нэг хүчин зүйл болдог нь тогтоогдсон.

Монгол улс:

Манай улсын хувьд “Төр сүм хийдийн харилцааны тухай” хуулийн 3 дугаар зүйл 5 дах хэсэгт: “Иргэний шашин шүтлэгийн байдлыг уг хүн өөрөө хүссэнээс бусад тохиолдолд албан баримт бичигт тусгахыг хориглоно” гэж заасан бөгөөд уг заалтын хүрээнд шүүгчийн сонгон шалгаруулахад шашин шүтдэг эсэх, ямар нэг хурал, цуглаанд хамрагддаг эсэх мэдээллийг тодруулах боломжгүй болгох магадлалтай.

Үндсэн хуулийн 14.2 “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэж заасан байна.

Бүгд Найрамдах Хятад Ард улс:

Тус улсын хувьд байгуулагдсан цагаасаа шашны эрх чөлөөг үндсэн хуульдаа тусгасан байдаг ч хэрэгжих боломжгүй гэж судлаачид үздэг. Учир нь Хятадын Коммунист намын гишүүн намын дүрэмд заасны дагуу шашингүй үзэлтэн байх ёстой бөгөөд шүүгчийн хувьд мөн ижил юм. Өөрөөр хэлбэл төрийн алба хашихын тулд үндсэн хуулиар олгогдсон эрхээсээ татгалзах ёстой болдог. Энэ заалт нь практикт хэрэгжих боломжгүй бөгөөд албан хаагчид шашингүй үзэлтэн гэх боловч үнэн хэрэгтээ ихэнх нь ямар нэг шашин, дотоод хүч, далдын хүчин зүйлд ямар нэг хэмжээгээр итгэдэг ажээ.

Эндээс үзэхэд хүний шашин шүтэх эсэх эрх чөлөөг хуулиар болон болон тодорхой дүрэм журмын хүрээнд хязгаарлаж болох ч бодит практикт үр дүнгүй байх магадлалтай.

Тус улсын хуульд үндсэн хуулиас гадна эрүүгийн хуульдаа иргэний шашны эрхийг зөрчсөн албан хаагчид 2 хүртэлх жилээр хорих ял шийтгэхээр тусгасан байдаг. Мөн шашны хэрэг зохицуулах тухай хуультай бөгөөд 2006 оноос дагаж мөрдөж эхэлсэн ч 2017 оноос шинэчлэн баталсан бөгөөд тус хуулиар шашны асуудлыг нарийвчлан зохицуулж өмнөх хуулиас ялгаатай нь төрийн зүгээс тавих хяналтыг илүү хатуу болгосон байдаг.

ОХУ:

Тус улс нь үндсэн хуулиар шашин шүтэх эрхийг тусгаагүй боловч “Шашны нэгдэл, шашин шүтэх эрх чөлөөний тухай хууль”-ийг 1997 онд төрийн ДУМ-аар баталж мөн ондоо “Холбооны зөвлөл”-өөс зөвшөөрч дагаж мөрдөж эхэлсэн. Уг хуульд холбооны улсын хувьд /бүрэлдэхүүнд багтах улсууд нь 5 өөр шашинтай/ бусдын шашинд хүндэтгэлтэй хандах, итгэл үнэмшил, сүсэг бишрэлийн асуудалд харилцан ойлголцол хүлээцтэй байдлыг эрхэмлэх нь зүйтэй гэж үзсэнээр ОХУ-ын төрийн дум уг хуулийг баталжээ. Гэвч энэ хуулиар олгогдсон шашин шүтэх, эс шүтэх эрхийг үндсэн хуульд заасан “ёс суртахуун, эрүүл мэнд, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол, үндэсний аюулгүй байдал”-тай холбоотой тохиолдолд хязгаарлаж болохоор тусгасан байдгаараа онцлог.

СҮМ БА ШҮҮХ ХОЁРЫН ХООРОНДОХ ХАНА

Америкийн хуульчдын холбооны мэргэжлийн хариуцлагын төв

Ёс зүй, мэргэжлийн хариуцлагын байнгын хорооноос 2019 оны хоёрдугаар сарын 14-ний өдрийн **485** дугаар албан ёсны Ёс зүйн дүгнэлтийн дагуу гэрлүүлж буй шүүгч “ижил хүйстэн” хосын гэрлэлтийг цуцлахаас татгалзаж болохгүй гэж заасан.

Уг ёс зүйн дүгнэлтийн дагуу “Гэрлэлтээ батлах нь шүүхийн заавал биелүүлэх үүрэг бөгөөд эхнэр, нөхөр хоёрын бэлгийн чиг хандлагаас үл хамааран ямар ч шүүгч даргалахаас татгалзаж болохгүй” гэдгийг тус дүгнэлтээр тодорхой харуулж байна. Цаашилбал, хэрэв гэрлэлтээ батлуулах нь шүүхийн шийдвэрт хамаарах үүрэг бол шүүгч эсрэг хүйстэн эсвэл ижил хүйстэн хосуудыг ялгаварлан гадуурхаж болохгүй. Хэрэв шүүгч зөвхөн гэр бүл, найз нөхдийн гэрлэлтийг удирдах эсэхээ өөрийн үзэмжээр шийдэж, гэрлэлтийг хийхээр шийдсэн бол шүүгч хосуудыг ялгаварлан гадуурхахыг хориглоно. Хос бүр хуулийн өмнө тэгш эрхтэй, шүүгч хосуудыг ёс зүйн хувьд ялгаж салгаж болохгүй.

Шүүгчийн ёс зүйн загвар дүрмийн 2.3(В) заалт:

Шүүгч нь шүүгчийн үүргээ гүйцэтгэхдээ үг хэллэг, үйлдлээр илт нэг талыг барьсан, гадуурхах, тэр дундаа арьс өнгө, хүйс, шашин шүтлэг, үндэсний гарал үүсэл, үндэс угсаа, хөгжлийн бэрхшээлтэй, нас, бэлгийн чиг баримжаа, гэр бүлийн байдал, нийгэм эдийн засгийн байдал, улс төрийн харьяалал зэргийг харгалзан шүүхийн ажилтан, шүүхийн албан тушаалтан болон шүүгчийн удирдлага, хяналтад байгаа бусад этгээдэд ийм үйлдлийг хийхийг зөвшөөрөхгүй ба дарамтлахыг хориглоно.

Үүнтэй холбоотой шүүгч ижил хүйстэн хосуудад ёслол үйлдэхийг эсэргүүцэж байгаа шүүгч гэрлэлтийн аливаа ёслолыг удирдахаас татгалзаж байгаа нь хууль зөрчсөн үйлдэл мөн үү гэдэг асуудал юм.

Охайо мужийн 15-001-р дүгнэлтээр аливаа гэрлэлтийг хийхээс татгалзах нь ижил хүйстнүүдийн гэрлэлтийг удирдахаас зайлсхийх нь нийгмийн цөөнхүүдийн эсрэг зохисгүй буюу “өрөөсгөл үзлийг илтгэнэ” гэж тодорхойлсон.

Үүний эсрэгээр, Аризонагийн Шүүхийн ёс зүйн 15-01-ийн санал бодол эсрэг байр суурьтай байсан бөгөөд хэрэв шүүгч өөр хүйстэй эсвэл ижил хүйстэн гэр бүл, найз нөхдийнхөө хооронд ялгаагүй бол шүүгч гэрлэлтийн ёслолын үйлчилгээг гэр бүлийн гишүүд, найз нөхдөдөө хязгаарлаж болно гэж тодорхойлсон.

Хосуудын хүйс, бэлгийн чиг хандлагаас хамааран иргэний гэрлэлтийг батлах, цуцлахыг эсэргүүцэж байгаа нь иргэний хуулиас үл хамааран хувийн шашны итгэл үнэмшлийг тулгаж байна гэсэн ойлголтыг илэрхийлж байгаа нь анхаарал татаж байна.

485 дугаар санал нь Орегон мужаас ирсэн сахилгын хэргийг хэлэлцсэн. Шүүгчийн шашны үзэл бодол нь шүүхийн үүрэг хариуцлагыг нь орхигдуулж байгааг тогтоожээ.

Тэрээр ижил хүйстэн хосуудын хооронд гэрлэлтийг зохион байгуулахаас зайлсхийсэн нь хор хөнөөл учруулахгүй гэж маргаж байсан, учир нь түүний хүчин чармайлт нь олон нийтийг бухимдуулах, ижил хүйстэн хосуудыг гомдоох зорилго агуулаагүй юм. Мэдээжийн хэрэг, ийм үзэл баримтлал нь Шүүхийн ёс зүйн үлгэрчилсэн дүрмийн 2.1-д заасан "үндсэн заавар"-тай шууд зөрчилдөж байна: "Хуулиар тогтоосон шүүгчийн албаны үүрэг нь бүх зүйлээс дээгүүр байх ёстой. шүүгчийн хувийн болон шүүхээс гадуурх үйл ажиллагаа."

485-р саналын нэг хэсэг биш ч гэсэн Вайоминг мужийн шүүхийн сахилгын хэргийг Орегон мужийн шүүхийн шүүгчийн өдрийн сахилга батаас иш татсан. Вайоминг мужийн Дээд шүүх "[Нили эсрэг Вайоминг Шүүхийн ёс зүй ба ёс зүйн комисс](#)"-д ([Neely v. Wyoming Commission on Judicial Conduct & Ethics](#)) ижил хүйстнүүдийн гэрлэлтийг хийхгүй гэж олон нийтэд зарласан шүүгчийг буруутгав. (Энэ хэргийн нэгэн сонирхолтой тайлбар нь шүүгч (Рут) Нили нь хуульч эсвэл хуулийн чиглэлээр бэлтгэгдээгүй байсан. Харин хотын зөвлөлөөс томилогддог хотын шүүхийн шүүгч байсан бөгөөд дараа нь орон тооны бус тойргийн шүүхээр томилогджээ. Нэг тухайн цагийн ажлын үндсэн үүргүүдийн нэг нь иргэний гэрлэлтийг гүйцэтгэх явдал юм.)

Үндсэндээ гэрлэлт нь шашны үйл ажиллагаа бус харин иргэний гэр бүлийн асуудал юм. Массачусетсийн Дээд шүүх Гудриджийн эсрэг Эрүүл мэндийн газар дээр дурдсанчлан ([Goodridge v. Department of Health](#)):

Энгийнээр хэлэхэд төр иргэний гэрлэлтийг бий болгодог. Массачусетс мужид иргэний гэрлэлт нь колоничлолын өмнөх үеэс эхлэн яг нэрээр нь ойлгогдож байсан бөгөөд энэ нь бүхэлдээ иргэний гэр бүл юм. Commonwealth v. Munson, 127 Mass. 459, 460466 (1879)-ийг үзнэ үү. ("Массачусетс мужид эрт дээр үеэс эхлэн хүчин төгөлдөр гэрлэлтийн шаардлагыг Колони, муж, Хамтын нөхөрлөлийн хуулиар зохицуулж ирсэн" гэдгийг тэмдэглэж, 1639-1834 оны хооронд гэрлэлтийн дүрмийг судалсан). Массачусетсийн гэрлэлтийг баталгаажуулахын тулд ямар ч шашны ёслол хийх шаардлагагүй.

Вайоминг мужийн Дээд шүүхийн эсрэг саналтай шүүгчид олонхын дүгнэлтийг эсэргүүцэж, Нили Вайоминг мужийн бүх шүүгчид ижил хүйстнүүдийн гэрлэлтийг хийхийг шаардана гэж маргаж байв.

Шүүхийн байр суурь нь шашны байр суурь биш бөгөөд "чин сэтгэлээсээ шашны итгэл үнэмшил" дээр үндэслэсэн аливаа илэрхийлэл, үйлдлийг шаарддаггүй. Ерөнхийлөгч Томас Жефферсоны 1802 онд Данбери баптистуудын нийгэмлэгт бичсэн захидалдаа АНУ-ын Үндсэн хуулийн "анхны" тайлбар гэж нэрлэж болох зүйлийг тусгасан байдаг. Үүнд: Хууль тогтоох байгууллага нь "шашин тогтох, бий болохыг хүндэтгэсэн, эсхүл түүнийг чөлөөтэй хэрэгжүүлэхийг хориглосон хууль гаргах ёсгүй" гэж тунхагласан Америкийн нийт ард түмний

энэ үйлдлийг би бүрэн хүндэтгэлтэйгээр тунхаглаж, Сүм ба Төрийн хооронд тусгаарлах хана босгож байна.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Шашин нь нэг талдаа ёс зүйн хэм хэмжээ, анхны хуулийн үүргийг гүйцэтгэдэг бөгөөд тухайн хүний итгэл үнэмшил шашны үнэт зүйлс дээр суурилдаг итгэлцлийн харилцаа юм. Шашин нь сүсэгтэн, дагагчийн үзэл суртал, үйл хөдлөлд "ухамсарлагдаагүй сэтгэхүй"-гээр хүртэл нөлөөлдөг оюунжсан үнэт зүйлсийн систем гэгддэг.

Үүнийхээ хувьд шүүгчийн шийдвэр гаргах ажиллагаанд шашны үзэл, ойлголт нь ухамсаргүй байдлаар хувь хүний үзлээр дамжин, шийдвэрт нөлөө үзүүлж байгаа нь дээрх судалгаануудад тодорхойлогдсон.

Уг судалгааны хүрээнд ОХУ, АНУ, Монгол, БНХАУ, ХБНГУ, Канад улсуудын талаар судалсан бөгөөд шүүгчийн шашин шүтэх, эс шүтэх талаар хязгаарласан мэдээлэл БНХАУ-аас бусад оронд тодорхой илрэлгүй бөгөөд үндсэн хууль бусад холбогдох хуулиар иргэдийн шашин шүтэх эрхийг хамгаалсан бөгөөд тодорхой албан үүрэг гүйцэтгэхэд шалгуур болохгүй байх гэсэн санааг тусгасан байна.

Манай улсын хувьд хүн амын нягтаршил нийслэлээс бусад засаг захиргааны нэгжүүдэд бага бөгөөд тодорхой хамаарал бүхий этгээдийн хэргийг шүүн таслах нөхцөл үүсэж болох ч шүүгч "Шүүхийн тухай хууль"-ийн 51.1 заалтын хүрээнд татгалзан гарах боломжтой.

